ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2026 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 18 гишүүн 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төсөл санаачлагч Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар, ялангуяа тариалангийн үйлдвэрлэл нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, зах зээлийн хэлбэлзлээс өндөр хамааралтай хэвээр байна. Ган, хэт халалт, хур тунадас багасах зэрэг цаг уурын эрсдэл нь ургацын хэмжээ, тариаланчдын орлогод шууд нөлөөлж, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, хүнсний хангамжид эрсдэл учруулж байгаа тул тариалангийн салбарын эрсдэлийг удирдах, тариаланчдын санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, гамшгийн дараах санхүү, төсвийн гэнэтийн хүндрэлийг бууруулах зорилгоор тариалангийн индексжүүлсэн даатгалын бие даасан эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоогоор улсын төсөвт урьдчилан тогтоосон тогтмол хэмжээний шинэ зардал шууд үүсгэхгүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой улсын төсвийн бодит нэмэлт хэрэгцээг хууль батлагдсаны дараа бүтээгдэхүүний актуар тариф, даатгалын хамрагдалт, Засгийн газраас тогтоох дэмжлэгийн нөхцөл, мэдээллийн дэд бүтцийн бодит хэрэгцээнд үндэслэн жил бүрийн төсөв боловсруулах үе шатанд нарийвчлан тооцох нь зүйтэй талаар дурдсан байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг ургацаа алдсан иргэн, аж ахуйн нэгж даатгуулсан нөхөн төлбөрөө бүрэн авч чадах эсэх, цаг уурын индексийг тогтоох дэд бүтэц бий эсэх, төрийн оролцоо болон улсын төсөвт үзүүлэх нөлөө, хууль батлагдсанаар жижиг аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх тодорхой дэмжлэг, уг хуулийн төсөлтэй уялдуулан Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг гаргасан эсэх, тариалангийн индексжүүлсэн даатгалыг зарим аймаг, сумдад турших хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат газар тариалангийн бүс нутгийн хэдэн хувийг хэдэн аж ахуйн нэгж эзэмшдэг, тухайн орон нутгийн иргэд газрыг газар тариалангийн зориулалтаар эзэмшиж, ашиглах боломжтой эсэх, мал бүхий иргэд, тариалан эрхлэгчид хоорондын харилцааг зохицуулах эсэх, давхар даатгалд оролцох гадаадын даатгалын байгууллагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат хөдөө аж ахуй, газар тариалангийн даатгалын асуудлыг бие даасан хуулиар зохицуулах шаардлага, мөн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн

талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хуулийн төсөл боловсруулахтай холбоотой оролцогч талуудын судалгаа, мэдээлэл, даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад шаардлагатай санхүүгийн нөөц бий эсэх, даатгалд ашиглах өгөгдөл, мэдээллийн үнэн зөв байдлыг хэрхэн баталгаажуулах, төсөвт үзүүлэх нөлөөний талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан хуралдаанд оролцсон гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр суууриа илэрхийлэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа бөгөөд төсвийн ачааллыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, татаас, хариуцах этгээд болон хэрэгжүүлэх механизм, тооцооллыг нарийвчлан тодорхойлж, ажлын хэсгийн хүрээнд уг хуулийн төслийг сайжруулах шаардлагатай талаар саналаа хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг баримтлан Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь, хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувь, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 55 хувь, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 60 хувь, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 70 хувийн саналаар тус тус дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА **Б.ЗАЯАБАЛ**